

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
4 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-14
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	15-125
	1. Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2019.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	15-20
	2. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	20-21
	3. Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	21-24
	4. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	24-26
	5. Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	27-29
	6. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 01 дүгээр дүгнэлтийг хүлээн авсантай холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	29-33
	7. “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын 2021 оны 38 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг	34-54
	8. Цаг үеийн шинжтэй асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл сонсох /Монгол Улсад үүсээд буй коронавируст цар тахлын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний явц, үр дүнгийн талаар/	54-100
	9. “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын 2021 оны 38 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг /үргэлжлэл/	100-101
	10. Цаг үеийн шинжтэй асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл сонсох /Монгол Улсад үүсээд буй коронавируст цар тахлын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний явц, үр дүнгийн талаар/ /үргэлжлэл/	102-122
	11. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/	122-125

**Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганы
4 дүгээр сарын 29-ний өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн хуралдааны**

Хураангуй тэмдэглэл

Гурав.Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын шинжээч Д.Цолмон, ахлах мэргэжилтэн А.Амармөрөн, Оюуны өмчийн газрын дарга Б.Энхсүх, мөн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга С.Ганзориг, Оюуны өмчийн хяналтын хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Аж үйлдвэрийн өмчийн эрхийн хэлтсийн дарга С.Урангэрэл, Монголын Оюуны өмч хамгаалах холбооны гүйцэтгэх захирал У.Тамир, Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Э.Одгэрэл, Монголын Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбооны гишүүн Д.Нэргүй нар “Их хуралдай” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг “Их хуралдай” танхимаас танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны
дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгасан
санал:**

Г.Занданшатар: 1.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 41.6, 41.7 дахь хэсэг болгох:

“41.6.Хараагүй, сонсголгүй, харааны, эсхүл сонсголын бэрхшээлтэй, хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлдэг төрийн болон эрх бүхий байгууллага, эсхүл дээрх байгууллагын албан тушаалтан нь бүтээлийг энэхүү хүмүүст хүртээмжтэй хэлбэрт хөрвүүлэн хуулбарлах, хил дамнуулан солилцох, хүлээн авах, түгээх, боловсролыг дэмжих зорилгоор мэдээллийн технологийн хэрэгслээр дамжуулан номын сангийн материалыг хүртээмжтэй болгож сургалтад ашиглах, бүтээлийг хичээлийн танхимд ашиглуулах, дэлгэж үзүүлэх, бүтээлийг зайны сургалтад зориулан хэсэгчлэн ашиглахыг зөвшөөрнө.

Тайлбар: Энэ хуульд заасан “хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбар” гэж хараагүй, сонсголгүй, харааны, эсхүл сонсголын бэрхшээлтэй, хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүнд бүтээлийг бусдын адил чөлөөтэй, саадгүй хүлээн авахад нь зориулан бүтээсэн сонгох боломжтой төрөл, эсхүл хэлбэрт хөрвүүлсэн хуулбарыг ойлгоно.”

41.7.Энэ хуулийн 41.1-д заасан зорилгоор бүтээлийн цахим хувийг олж авахаар эрх бүхий байгууллага хандсан бол тухайн цахим хувийг хадгалж байгаа байгууллага, хувь хүн саадгүй гаргаж өгөх үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	38
Татгалзсан:	21
Бүгд:	59

64.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны
дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгасан
санал:**

Г.Занданшатар: 1.Төслийн гарчгийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Оюуны өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “хянах,” гэснийг “хянан баталгаажуулах, төлбөр төлөх, хуваарилахтай холбоотой гомдлыг урьдчилан шийдвэрлэх” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	41
Татгалзсан:	18
Бүгд:	59

69.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн дугаарыг “3 дугаар зүйл” гэж, 3 дугаар зүйлийн дугаарыг “4 дүгээр зүйл” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	45
Татгалзсан:	14

Бүгд: 59
76.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын шинжээч Д.Цолмон, ахлах мэргэжилтэн А.Амармөрөн, Оюуны өмчийн газрын дарга Б.Энхсүх, мөн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга С.Ганзориг, Оюуны өмчийн хяналтын хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Аж үйлдвэрийн өмчийн эрхийн хэлтсийн дарга С.Урангэрэл, Монголын Оюуны өмч хамгаалах холбооны гүйцэтгэх захирал У.Тамир, Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Э.Одгэрэл, Монголын Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбооны гишүүн Д.Нэргүй нар “Их хуралдай” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Золжаргал, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг “Их хуралдай” танхимаас танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг хариулж, тайлбар хийв.

Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

***Гурав.Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн
найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд
/Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг/***

Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын эрхэм гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2021 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаараа Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан болно.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хуульд зохих өөрчлөлт оруулах шаардлага үүсч байгаа бөгөөд хууль санаачлагч Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийг өргөн мэдүүлээгүй тул холбогдох өөрчлөлтийг тусгасан хуулийн төслийг даруй өргөн мэдүүлэх нь зүйтэй талаар санал хэлж, Байнгын хорооны хуралдааны тэмдэглэлд тусгуулсан болно.

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөвлөл нь зохиогчийн эрхийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, бүтээл ашиглалтын тарифыг хянан баталгаажуулах, төлбөр төлөх, хуваарилахтай холбоотой гомдлыг урьдчилан шийдвэрлэх чиг үүрэгтэй байх санал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэнтэй холбогдуулан Оюуны өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт зохих өөрчлөлтийг тусгах зарчмын зөрүүтэй саналыг ажлын хэсгээс гаргасан, түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулах үед хуулийн төслийн 41 дүгээр зүйлийн 41.6 дахь хэсэгтэй холбоотой санал дэмжигдсэн бөгөөд тус хэсгийг илүү нарийвчлан зохицуулж хараагүй, сонсголгүй, харааны эсхүл сонсголын бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэдээлэл олж авах эрхийг хангах нь зүйтэй талаар санал гаргасан тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасныг баримтлан хэлэлцэж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйнь зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулга зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Цахимаар байна уу? Алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй гурван санал байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгасан санал байна.

1.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 41.6, 41.7 дахь хэсэг болгох.

“41.6.Хараагүй, сонсголгүй, харааны, эсхүл сонсголын бэрхшээлтэй, хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлдэг төрийн болон эрх бүхий байгууллага, эсхүл дээрх байгууллагын албан тушаалтан нь бүтээлийг энэхүү хүмүүст хүртээмжтэй хэлбэрт хөрвүүлэн хуулбарлах, хил дамнуулан солилцох, хүлээн авах, түгээх, боловсролыг дэмжих зорилгоор мэдээллийн технологийн хэрэгслээр дамжуулан номын сангийн материалыг хүртээмжтэй болгож сургалтад ашиглах, бүтээлийг хичээлийн танхимд ашиглуулах, дэлгэж үзүүлэх, бүтээлийг зайны сургалтад зориулан хэсэгчлэн ашиглахыг зөвшөөрнө.

Тайлбар: Энэ хуульд заасан “хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбар” гэж хараагүй, сонсголгүй, харааны, эсхүл сонсголын бэрхшээлтэй, хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүнд бүтээлийг бусдын адил чөлөөтэй, саадгүй хүлээн авахад нь зориулан бүтээсэн сонгох боломжтой төрөл, эсхүл хэлбэрт хөрвүүлсэн хуулбарыг ойлгоно.”

41.7.Энэ хуулийн 41.1-д заасан зорилгоор бүтээлийн цахим хувийг олж авахаар эрх бүхий байгууллага хандсан бол тухайн цахим хувийг хадгалж байгаа байгууллага, хувь хүн саадгүй гаргаж өгөх үүрэгтэй.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 59 гишүүн оролцож, 38 гишүүн дэмжиж, 64.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хоёр.Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгасан санал байна.

1.Төслийн гарчгийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Оюуны өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “хянах,” гэснийг “хянан баталгаажуулах, төлбөр төлөх, хуваарилахтай холбоотой гомдлыг урьдчилан шийдвэрлэх” гэж өөрчилсүгэй.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 59 гишүүн оролцож, 41 гишүүн дэмжиж, 69.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн дугаарыг “3 дугаар зүйл” гэж, 3 дугаар зүйлийн дугаарыг “4 дүгээр зүйл” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 59 гишүүн оролцож, 45 гишүүн дэмжиж, 76.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.